

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН  
(2023 он)

2023.12.28

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА				Хэрэгжилт
				2020	2021	2022	2023	
<b>Зорилт 1. Ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх</b>								
1.1	Байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартад нийцүүлэн ажлын байрны хэрэгцээг тодорхойлон, хүний нөөц бүрдүүлэлтийг дотоод болон гадаад нөөцөөс бүрдүүлэх	хүний нөөцийн зохистой харьцаа бүрдэнэ	Батлагдсан орон тооны хангалтын хувь					<p>Хүний нөөцийн удирдлагад ил тод байдлыг хэрэгжүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж ажилд авах журам”-ыг эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын А/31 дүгээр тушаалаар шинэчлэн батлаж, мөрдөн ажиллаж байна. Журмыг эмнэлгийн албан ёсны цахим хуудсанд нийтэд ил тод байршуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/564 дүгээр тушаалын дагуу Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/41 дүгээр тушаалаар “Эмнэлгийн бүтэц, орон тоо, хүний нөөцийн төлөвлөлт”-ийг нийт 566 ажилтны орон тоотойгоор батлан 2023 онд 556 буюу 98.3%-ийн хангалттайгаар төв эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэн ажилласан.</li> <li><a href="https://info.shilendans.gov.mn/">https://info.shilendans.gov.mn/</a> “Шилэн данс”-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан.</li> <li>2023 онд нийт 54 ажлын байранд давхардсан тоогоор 145 удаа сонгон шалгаруулах зарыг эмнэлгийн вэб хуудас <a href="http://ssch.gov.mn/">http://ssch.gov.mn/</a>, эмнэлгийн фейсбүүк фейжд ил тод байршуулсан. 2023 онд нийт 146 ажилтныг сонгон шалгаруулж шинээр ажилд авсан. Үүнээс 36 эмч, 55 сувилагч, туслах сувилагч, 24 үйлчлэгч, 31 бусад ажилтнууд байна.</li> <li>2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Этүгэн их сургууль, 04 дүгээр сарын 21-ний өдөр АШУҮИС-ийн Сувилахуйн</li> </ul>

								<p>сургуулийн төгсөх дамжааны оюутнуудтай ажил олгогчдын нэгдсэн уулзалт арга хэмжээнд оролцож шинэ төгсөх сувилагч нарт эмнэлгийн давуу тал, хөгжих бололцоо зэргээр танилцуулга хийж, сувилагчаар ажиллах урилга өгсөн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2023 оны 04 дүгээр сарын 27-ний өдөр Дархан-уул аймгийн анагаах ухааны сургуулийн ажил олгогч, төгсөгчдийн уулзалтанд байгууллагаа сурталчилах, сувилахуйн хүний нөөцийн бүрдүүлэлт хийх зорилготой оролцож бакалаврын 10, дипломын 4 оюутанд ажлын байрны батламж гардуулсан.</li> </ul>
1.2	Нээлттэй ажлын байранд ажилтанг хүний нөөцийг сонгон шалгаруулах журмын дагуу ил тод сонгон шалгаруулж, хүний нөөцийг бүрдүүлэх	Хүний нөөцийн ил тод байдал хангагдана.	Нээлттэй сонгон шалгаруулалтын зарлалын тоо Шинээр авсан ажилтны тоо					<ul style="list-style-type: none"> <li>• Ажилд орохыг хүссэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанг “Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж ажилд авах журам”-ын дагуу Удирдлагын зөвлөлийн хурал болон тасгийн хамт олны хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр ил тод, нээлттэйгээр сонгон шалгаруулж ажилд авч, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан.</li> <li>• Иргэд болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнаас байгууллагын хүний нөөцийн удирдлагатай холбоотой гарсан гомдол байхгүй болно.</li> <li>• Шинээр ажилд орсон нийт 146 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан</li> </ul>
1.3	Эмч, ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтыг мэргэжлийн төлөөлөлийн саналд тулгуурлан шинэчлэн боловсруулах	Ажил үүрэг тодорхой болж ажлын ачаалал тэнцвэртэй болно	Шинэчлэн боловсруулсан албан тушаалын тодорхойлолтын тоо					<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу Захиргаа, хүний нөөцийн албаны 5, Мэдээллийн технологийн албаны 2, Ариутгал халдваргүйтгэлийн тасгийн 7, Тусгай тасгийн 7, Инженерийн байгууламжийн албаны 11, нийт 5 алба, тасгийн 32 албан тушаал, 58 мэргэжилтэн, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан. (Ерөнхий захирлын 2023 оны А/34, А/38, А/43, А/46, А/52 дугаар тушаал)</li> </ul>

1.4	Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажилласан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоо						Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчийн нийт тоо-3
-----	---	---	----------------------------------	--	--	--	--	--	--

**Зорилт 2. Хүний нөөцийн тогтвортой хөгжлийг хангаж, чадаахыг бэхжүүлэх**

2.1	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн тасралтгүй сургалтын багц цагийн бүрдүүлэлт 100% биелүүлэх, багц цаг бүрдүүлэлтийн 1 багц цаг нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрх зүйн чиглэлээр байх	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн багц цаг бүрдүүлэлт 100% байна. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрхзүйн мэдлэгийг нэмэгдэнэ.	Багц цаг бүрдүүлэлтийн тайлан						<ul style="list-style-type: none"> <li>• 2023 онд тус эмнэлэг нь 16 сэдвээр 22 удаагийн багц цагийн сургалтыг танхим/цахим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 2000 эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг тасралтгүй сургалтад хамруулсан байна.</li> <li>• Амьдралд суурилж суралцахуй ТББ-д эмнэлгийн Сувилахуйн албаны (Ёс зүйн салбар хороо)-ны зүгээс “Мэргэжилтэний ёс зүй-Харилцааны ур чадвар 1 багц цагийн сургалтыг эмч, сувилагч, эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтэн, ажилтануудад авах хүсэлт илгээсний дагуу тасралтгүй хөгжүүлэх нэн чухал асуудал болж буй эмнэлгийн мэргэжилтний Ёс зүй-Харилцаа хандлагын сургалтыг 2023 оны 02 дүгээр сарын 14-ний 14.00 цагт ҮОЭТ-ийн хурлын танхимд АШУҮИС-ийн БАС-ийн тэнхимийн багш С.Наранчимэг /АУ-ны доктор, профессор/, С.Нармандах /докторант/ нартай хамтран зохион байгуулж нийт 124 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан. Сургалтын үр дүнд эмч, сувилагч, эмнэлгийн ажилтууд биеэ авч яваа байдал, өөрийн бодол, биеийн хэлэмж, үгийн сонгол, дууны өнгөөс сэтгэлээсээ хандаж буй эсэхэд анхаарах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид хэрхэн яаж хүрэх зэргээр дадлага онол хосолсон сургалт боллоо.</li> <li>• Эмнэлгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд болон ажилтнуудад “Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ ба ажлын бүтээмж” сэдэвт 2 багц цагийн сургалтын удирдамжийг Эмнэлгийн</li> </ul>
-----	--	--	-------------------------------	--	--	--	--	--	--

								<p>мэргэжилтний ёсзүйн хяналтын хорооны дарга, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр батлуулан эмч, эм зүйч нарт 2023 оны 11 дүгээр сарын 10-нд зохион байгуулж 194 эмч, эм зүйч нар хамрагдсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>“Байгууллагын соёл”, Эмнэлгийн ажилтны харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ ба ажлын бүтээмж” сэдэвт 2 багц цагийн сургалтын сувилагч, дэмжих үйлчилгээний ажилтнуудад 2023 оны 11 дүгээр сарын 23-нд 150 сувилагч, ажилтнууд хамрагдсан.</li> </ul>
2.2	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн хэрэгцээнд нийцсэн богино хугацааны тасралтгүй сургалтыг зохион байгуулах	Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн мэдлэгийг нэмэгдэнэ.	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан мэргэжилтнүүдийн тоо					<ul style="list-style-type: none"> <li>2023 оны хичээлийн жилд шинээр элсэн суралцсан 40 резидент эмч, 28 сувилагчид 3 хоног чиглүүлэх сургалтад хамруулсан.</li> <li>Мөн 2022 оны 6 дугаар сараас 2023 оны 5 сар хүртэлх шинээр орсон эмч, эрүүл мэндийн ажилтны дунд халдвараас сэргийлэх хяналт, ipsg 6 зорилтын талаар сургалт 2023 оны 04 дүгээр сарын 25,27 5 дугаар сарын 2-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нийт 70 шинээр орсон эрүүл мэндийн ажилтанд сургалт хийсэн.</li> <li>2023 оны 02 дугаар сарын 16 өдөр шинээр ажилд орсон үйлчлэгч, сувилагч, сувилагчийн туслах нийт 22 эрүүл мэндийн ажилтанд сургалт зохион байгуулсан.</li> <li>2023 оны 04 дүгээр сарын 13 өдөр нийт хангамж үйлчилгээний ажилтан, шинээр орсон сувилагч нар нийт 44 эрүүл мэндийн ажилтанд сургалт зохион байгуулсан.</li> <li>Сувилахуйн албанаас туслах сувилагчаар ажиллаж буй 14 оюутанд байгууллагын танилцуулга, тасаг нэгжийн онцлог, ажил үүргийн хуваарийн талаар 2023 оны 03 сард зохион байгуулсан</li> <li>Шинээр ажилд орсон 32 сувилагч мэргэжилтнийг шинэ ажилтаны сургалтын хөтөлбөрийн дагуу 4 удаагийн онол, 9 удаагийн ур чадварын сургалтанд хамруулсан.</li> <li>2023 оны 06 сарын 21-нд Нийслэлийн иргэдийн хэрэглээний боловсролын төв, Нийгмийн эрүүл мэнд, тандалтын алба хамтран эмнэлгийн дэмжих албаны 68 ажилчдад ажлын байран дахь эрүүл зөв хооллолт,</li> </ul>

								<p>амьдралын зөв дадал зуршил, хамт олны дотоод харилцаа, уур амьсгал сэдэвт эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 5 дугаар зорилтын хүрээнд эрүүл мэндийн ажилтныг чадавхижуулах талаар 2023 оны эхний улиралд хэвтэн болон хэвтэн бус тасгуудын дунд халдвар хяналт болон эмнэлгийн тусламж үйлчилгээ аюулгүй байдлын чиглэлээр нийт 24 тасаг нэгжүүд дотоодоо сургалт зохион байгуулсан.</li> <li>• Эмнэлгийн удирдах ажилтан сургалтыг “Хүний хөгжил хөлдөлмөр хамгаалал” Төрийн бус мэргэжлийн байгууллагаас сургалт хийгдэж 38 ажилтан танхимаар, онлайнаар 10 эмч нар нийт 48 ажилтан оролцов.</li> <li>• Нийт 21 тасаг алба нэгжүүдэд ХАБ-ын ажилтан “Аюулгүй ажиллах ажлын байр”, “Гал аюулгүй байдал, галын хорыг ажиллуулж сурах” сэдэвтэй сургалтыг нийт ажилчдын 350 хүний 75% оролцсон байна.</li> <li>• 2023 оны хөдөлмөр хамгаалал сарын аяны хүрээнд мэргэжлийн байгууллагаас “Гал импекс” ХХК-ны сургагч багш А.Батмөнх “Галын аюулгүй байдал, газар хөдлөлд бэлэн байх, газар хөдлөлт, түүнийг авах арга хэмжээ” сэдэвтэйгээр зохион байгуулж нийт ажилчдад 50%-тай оролцов</li> </ul>
2.3	Лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний чиглэлүүдээр дүүрэг, орон нутгийн эмнэлгүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	Үйлчлүүлэгч, иргэд орон нутагтаа чанартай тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж ажиллана.	Зохион байгуулсан, арга хэмжээний тайлан					<ul style="list-style-type: none"> <li>• Ховд аймгийн Нэгдсэн эмнэлгийн тогооч 3-р сард 14 хоногийн хугацаатай Хоол шим тэжээлийн тасагт дадлага сургалтад хамрагдсан.</li> <li>• Багануур дүүргийн ЭМТ-ийн мэдрэлийн эмч нар Харвалтын тасагт 4-р сард дадлага хийсэн.</li> <li>• Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэдээгүйжүүлэгийн эмч 4-р сард Өвдөлт намдаах кабинетэд 14 хоногийн эмнэлзүйн дадлага сургалтад хамрагдсан.</li> <li>• Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын эмч, Налайх дүүргийн ЭМТ-ийн мэс заслын эмч дурангийн мэс</li> </ul>

								<p>заслын мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалтад хамрагдсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлага, эмч нар нийт 15 хүн, Баянхонгор аймгийн Өрхийн эрүүл мэндийн төвийн 24 эмч, сувилагч нар, мөн Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн Мэдрэл судлалын тасгийн 2 эмч, 3 сувилагч нарын бүрэлдэхүүнтэй хөдөө, орон нутгийн төлөөлөгчид 2023 оны 04-р сарын 07-27-ны өдрүүдийн хооронд тус эмнэлэгт зочилж, Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагаатай танилцлаа.</li> <li>• 2023 оны 06 дугаар сарын 07-нд Дорнод аймгийн БОЭТ-ийн эмч нарын баг манай эмнэлгийн эмнэлзүйн зохицуулалт, статистик, чанар, хүний нөөц, МЭЭТ, мэс засал, хүүхэд зэрэг алба тасгийн үйл ажиллагаатай танилцлаа.</li> <li>• Зүрх судас судлалын тасгийн хамт олон 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Төв аймгийн Батсүмбэр суманд байрлах ахмад настаны үндэсний төвд ажиллан 10 эмч 2 сувилагчийн бүрэлдэхүүнтэй баг 110 ахмад настанд зүрхний эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийж, эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн.</li> <li>• Мэдрэл судлалын тасгаас 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Архангай аймгийн Тариат сумын Асгат /Алтаад/ багт ажиллалаа. Асгат багийн 32 малчинд багийн эмч хамт нарийн мэргэжлийн мэдрэлийн эмчийн үзлэг оношилгоо хийж, эрүүл мэндийн зөвлөгөө өгч харвалтын эрсдлийг тодорхойллоо. Тархины харвалт үүсэх өндөр эрсдэлтэй 6 малчинг илрүүлж дэлгэрэнгүй зөвлөгөө өглөө.</li> <li>• Халдвар судлаач эмч Ц.Уянга магадлан итгэмжлэлийн шинжээчээр нийт улс, нийслэл, орон нутгийн 22 эрүүл мэндийн байгууллагад ажилласан. Халдварын сэргийлэлт хяналт, барилга, тоног төхөөрөмж, мэдээллийн удирдлагын аюулгүй байдал, эмчилгээний хоол, цус сэлбэлтийн</li> </ul>
--	--	--	--	--	--	--	--	---

								<p>аюулгүй байдал чиглэлээр давхардсан тоогоор 220 зөвлөмж бичгээр өгсөн байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Сувилахуйн албанаас Налайх дүүргийн эрүүл мэндийн төвийн 45 сувилагч мэргэжилтэнд “Сувилахуйн тусламжийн эрсдэлийн үнэлгээ” сэдвээр сургалт зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</li> <li>• ЭМС-ын 2023 оны А/256 тоот Эрт илрүүлэг, шинжилгээ, оношилгоог эрчимжүүлэх тухай тушаалын дагуу Эмнэлгийн явуулын үзлэгийн баг Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Төв, Ховд, Говь-Алтай аймгуудаар нийт 53 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны бүрэлдэхүүнтэй явж эрт илрүүлгийн үзлэгийг 5527 хүнд хийсэн.</li> <li>• 2023 оны 10 дугаар сарын 5-8ны өдрүүдэд Ерөнхий мэс заслын эмч нарын баг Дорнод аймагт 5 хоног ажлын байран дээрх дурангийн мэс заслын сургалт хийсэн.</li> <li>• 2023 оны 10 дугаар сарын 16-20 өдрүүдэд Ерөнхий мэс заслын эмч нарын баг Орхон аймагт 5 хоног олон улсын ивэрхийн сангийн 3 эмчтэй хамтарч ажлын байран дээрх ивэрхийн мэс заслын сургалт хийсэн.</li> </ul>
2.4	Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх сургалтын төлөвлөлтийг хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, төрөлжсөн нарийн мэргэжлийн чиглэлд нийцүүлэн гаргаж, шударга зарчмаар сонгон нэрийг дэвшүүлж хэрэгжүүлэх	Эмнэлгийн хүний нөөцийн чадавхи нэмэгдэнэ.	Сургалтад хамрагдсан мэргэжилтн ий тоо					<ul style="list-style-type: none"> <li>• Мэдрэлийн мэс засал-1, хүүхдийн мэдээгүйжүүлэг судлал-1, эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал-2, мэдрэл булчингийн бичлэг-3, хүүхдийн эрчимт эмчилгээ судлал-1, гемодиализ-1, дурангийн онош зүй-1, мэдрэлийн хөдөлгөөн засал судлал-1, Тархи судасны хэт авиан доплерографи-2, Тархины цахилгаан бичлэг-2, судсан дотуурх оношилгоо, эмчилгээ-1, эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын менежер-3 буюу 18 эмч, 1 хөдөлгөөн засалч нийт 19 эмч, эмнэлгийн мэргэжилтэн төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх дотоодын сургалтад хамрагдсан. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сургалтанд хамрагдах хугацаанд үндсэн цалинг олгосон.</li> <li>• Мэргэжил дээшлүүлэх болон төрөлжсөн мэргэшил эзэмших 3-6 сарын дотоодын сургалтад Яаралтай тусламжийн</li> </ul>

								сувилахуй-1, Эрчимт эмчилгээний сувилахуй-7, Мэс заслын сувилахуй-15, хавдрын сувилахуй-2, дурангийн онош зүй-2, мэдээгүйжүүлгийн сувилахуй-2 нийт сувилагч мэргэжилтнийг байгууллагын захиалгаар үүнээс 24 мэргэжилтнийг төрийн сангийн санхүүжилтээр суралцуулсан. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сургалтанд хамрагдах хугацаанд нь үндсэн цалинг олгосон.
2.5	Өндөр хөгжилтэй орны эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй хамтарсан сургалт хийх	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд өндөр технологи, ур чадвар шаардсан тусламж, үйлчилгээг үзүүлэх сургалт зохион байгуулагдана.	Сургалтын тайлан					<ul style="list-style-type: none"> <li>• 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цар тахлын дараах сэргэлт, цаашдын чиг хандлага” эрдэм шинжилгээний хурлыг Олон улсын Сэнт Мэри эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулсан.</li> <li>• 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр “Бөөрний эдийн шинжилгээнд үндэслэж бөөрний өвчийг оношлох, эмчлэх нь” сургалтыг АНУ-ын Жонс Хопкинс их сургуулийн эмнэлгийн профессоруудтай хамтран зохион байгуулсан.</li> <li>• 2023 оны 10 дугаар сарын 28-ны өдөр “ЭРДМИЙН ЧУУЛГАН-45” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг БНСУ-ын Канбуг Самсунг эмнэлэг, Япон улсын Канагава хавдрын төвийн судлаач нартай хамтран зохион байгуулсан.</li> <li>• 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр “Үйлчлүүлэгч болон эмч мэргэжилтний аюулгүй байдал: Эмнэлгийн орчны цацрагийн хамгаалалт” сэдэвт сургалтыг КОФИИ байгууллага, Камбуг Самсунг эмнэлэг, Багануур дүүргийн эрүүл мэнд төв, Дорнод аймгийн БОЭТ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулж нийт 77 хүн хамрагдсан.</li> </ul>
2.6	Удирдах ажилтан, эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудыг олон улсын болон дотоодын байгууллагын зохион байгуулж байгаа хувь хүний хөгжил, ёс зүй, манлайлал сэдэвт сургалтанд хамруулах	Байгууллагын соёл тогтворжиж, хувь хүний ёс зүй дээшилнэ.	Сургалтын тайлан					<ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийн яамнаас Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газрын харьяа Удирдлагын академитай хамтран “Эрүүл мэндийн удирдлага”-ын чиглэлээр мэргэшүүлэх богино хугацааны сургалтад Санхүү, бүртгэлийн албаны нягтлан бодогч, Бөөрний мэс заслын тасгийн эрхлэгч нар хамрагдаж байна.</li> </ul>

								<ul style="list-style-type: none"> <li>• БНСУ-ын KOFIN төслийн хүрээнд Канбуг Самсунг эмнэлэг дээр эмнэлгийн менежмент, үйл ажиллагааны сургалтад эмнэлгийн захирал, дэд захирал, албаны дарга нар бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэй баг богино хугацааны сургалтад хамрагдсан.</li> <li>• Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын А/71 тоот тушаалаар Япон улсад сувилахуйн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн хүрээнд богино хугацааны сургалтад 2 сувилагч хамрагдсан.</li> <li>• БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны Олон улсын монгол эмнэлэгт эмнэлгийн удирдлага зохион байгуулалтын богино хугацааны сургалтад 3 эмч, 5 сувилагч, 1 тусгай мэргэжилтэн, 1 ажилтан нийт 10 ажилтан хамрагдсан.</li> </ul>
2.7	Эмч, мэргэжилтнүүдийг эмнэл зүйн сургагч багшаар мэргэшүүлэх	Эмч,мэргэжилтнүүдийн ур, чадвар нэмэгдэж, эмнэлзүйн сургагч нарын нөөц бүрдэнэ.	Эмнэл зүйн сургагч багшийн тоо					<ul style="list-style-type: none"> <li>• Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтыг удирдан зохион байгуулах эмнэлзүйн сургагч багшийн шалгуурыг хангасан 4 эмч хамрагдсан.</li> <li>• Сувилахуйн эмнэлзүйн сургагч багш 12 ажиллаж байгаа. Байгууллагын зардлаар 23 сургагч багш шинээр бэлтгэгдсэн.</li> </ul>
2.8	Ажилтнуудын ажлын идэвхийг тогтмол сэргээхэд чиглэсэн ажил, мэргэжлийн болон ур чадварын уралдаан, тэмцээнийг тогтмол явуулах, урамшуулах	Ажилтнуудын идэвхи дээшилж, найрсаг, эвсэг хамт олон байх нөхцөл бүрдэнэ.	Зохион байгуулагдсан үйл ажиллагааны тоо, тайлан					<ul style="list-style-type: none"> <li>• Эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасгуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилтыг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл сахилтын түвшинг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зорилготой “Хяналт үнэлгээ-Чанартай үйлчилгээ” сэдэвт 1 сарын аяныг нийт хэвтүүлэн эмчлэх тасгуудын дунд дараах зорилтыг дэвшүүлж ажилласан. Аяны хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд: 1. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдэлийг үнэлэх</li> </ul>

										<p>2. Эрүүл мэндийн ажилтны халдварын сэргийлэлт хяналтын мэдлэг хандлагыг дээшлүүлэх, үнэлэх</p> <p>3. Эрүүл мэндийн ажилтны гар угаалт, халдваргүйтгэлийн түвшинг нэмэгдүүлэх</p> <p>4. Эрүүл мэндийн ажилтныг МТСА илрүүлэх шинжилгээнд хамруулах, хариу арга хэмжээ авч ажилласан.</p> <p>Аяны үр дүнд халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр олон эмэнд тэсвэртэй бичил биетний халдвар, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэл, эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл ахуйн талаар нийт 34 тасаг нэгжийн 230 эмч, эрүүл мэндийн ажилтан тасаг бүртээ сургалт зохион байгуулж үүнийг эмнэлгийн хаалттай цахим хуудсанд байршуулсан. Мөн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах, чанартай эмчилгээ үйлчилгээ, халдварын хяналт сэргийлэлтийн чиглэлээр видео шторк уралдаан зохион байгуулж, хэвтэн эмчлүүлэх тасгаас 1-р байр Зүрх судас судлалын тасаг, 2-р байр Бөөр дотоод шүүрлийн тасаг, 3-р байр Тусгай тасаг тус бүр шалгарч, талархлын бичиг, мөнгөн шагналаар шагнасан. Аяны хүрээнд нийт 13 тасаг нэгжид ЭМТҮЧАБА болон сувилахуйн албатай хамтарсан аюулгүй байдлын тойрон үзэг, дотоод хяналт үнэлгээ 8, зөвхөн халдвар хяналтын үйл ажиллагааны талаарх хяналт 5 хийгдсэн байна. Дэмжих тасаг болон хэвтэн бус тасгуудын дунд “Үйлчлүүлэгчийн аюулгүй орчин” сэдэвт 1 сарын аян зохион байгуулсан. Аяны хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдэлийг үнэлэх</li> <li>• Эрүүл мэндийн ажилтны халдварын сэргийлэлт хяналтын мэдлэг хандлагыг дээшлүүлэх, үнэлэх</li> <li>• Эрүүл мэндийн ажилтны гар угаалт, халдваргүйтгэлийн түвшинг нэмэгдүүлэх</li> <li>• Тоног төхөөрөмж, хатуу гадаргуугийн халдваргүйтгэл, цэвэрлэгээний үйл ажиллагааг төлөвшүүлэх</li> <li>• Эрүүл мэндийн ажилтны хувийн хамгаалах хэрэгслийн зөв дадлыг хэвшүүлэх талаар аян хийгдсэн.</li> </ul>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

								<p>Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах, чанартай тусламж, үйлчилгээ, халдварын хяналт сэргийлэлтийн чиглэлээр видео шторк уралдаан зохион байгуулж, хэвтэн эмчлүүлэх тасгаас 1-р байр Нэгдсэн лабораторийн тасаг, 2-р байр Цөмийн оношилгоо эмчилгээний төв, 3-р байр Ариутгал, халдваргүйтгэлийн тасаг тус бүр шалгарч, талархлын бичиг, мөнгөн шагналаар шагнасан. Дээрх аяны үр дүнд 2023 оны эхний улиралд Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийг дэмжих санд төсөл бичин шалгарч санхүүжилт авснаар эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасгуудын дунд “Хяналт үнэлгээ-Чанартай үйлчилгээ” сэдэвт 1 сарын аяныг, дэмжих үйлчилгээний тасгууд болон хэвтэн бус эмчилгээ оношилгооны тасгуудын дунд “Үйлчлүүлэгчийн аюулгүй орчин” сэдэвт 1 сарын аяныг тус тус зохион байгуулсан. Аян, уралдааныг өрнүүлснээр үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилтын хэрэгжилт 20%-иар нэмэгдэж, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр 18 эрсдэлийг тодорхойлж, үнэлэн, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан. Эрүүл мэндийн ажилтны халдварын сэргийлэлт хяналтын мэдлэг хандлагыг дээшлүүлэх сургалт үр дүнд дундаж үнэлгээ сургалтын өмнө 63.8%-иас сургалтын дараах үнэлгээ 70.2% болж өссөн. Гар угаалт, халдваргүйжүүлэлтийн хувь 10.6%-иар нэмэгдэж гар угаах мэдлэг хандлагыг дээшлүүлсэн. Түүнчлэн тоног төхөөрөмж, хатуу гадаргуу халдваргүйтгэл, цэвэрлэгээг чанаржуулж, хяналтын хуудас, бүртгэл хөтлөлтийг сайжруулсан. Эрүүл мэндийн ажилтны хувийн хамгаалах хэрэгслийн хангамж, зөв дадлыг 12%-иар нэмэгдүүлсэн гэх мэт тодорхой ахиц гарсан. Аян, уралдаанд эхний 3 байр эзэлсэн тасгуудад мөнгөн урамшуулал олгосон.</p> <ul style="list-style-type: none"><li>• ЭМЯ-наас 2023 оны туршид хүн амын дунд зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл идэвхтэй амьдралыг сурталчлах, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор зохистой хооллолт, дасгал хөдөлгөөнийг дэмжих замаар таргалалтыг бууруулах “Энэ жилдээ-эрүүл жиндээ” аяныг үндэсний хэмжээнд өрнүүлж байгаа билээ. Энэхүү аяны хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Цэргийн төв эмнэлгийн (ЦТЭ)-ийн</li></ul>
--	--	--	--	--	--	--	--	--

							<p>мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад сурч байгаа резидент, суралцагч нарын дунд нөхөрсөг спортын 4 төрөлт тэмцээнийг 05 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж, тэргүүн байранд шалгарсан баг тамирчдад батламж, медаль, мөнгөн шагналыг гардуулав. Тус тэмцээний үеэр УХТЭ, ЦТЭ-ийн резидент, суралцагч эмч нар нь дотносон танилцахын зэрэгцээ хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх, тоглолтын техник ур чадвараа дээшлүүлсэн, тоглолтын арга туршлага солилцсон нөхөрсөг тэмцээн болж өндөрлөө.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эмнэлгийн санаачлагаар зүүн бүсийн эрүүл мэндийн байгууллагуудын спортын 5 төрөлт тэмцээн Багануур дүүрэгт 2 өдөр амжилттай болж өндөрлөлөө. Энэ удаагийн нөхөрсөг уулзалт тэмцээн нь "ЭНЭ ЖИЛДЭЭ ЭРҮҮЛ ЖИНДЭЭ" үндэсний хэмжээний аяныг сурталчлах, эрүүл мэндийн ажилтнууд үлгэрлэн манлайлах зорилгоор нийт 7 байгууллагын 200 гаруй тамирчид авъяас самбаагаа уралдуулан өндөр зохион байгуулалтын дор өрсөлдлөө. Багийн дүнгээр Багануур эрүүл мэндийн төв шилжин явах цом 1-р байр, УХТЭ 2-р байр, Сүхбаатар нэгдсэн эмнэлэг 3-р байрыг тус тус эзлэв. 2024 онд зүүн бүсийн спортын наадам Сүхбаатар аймагт зохион байгуулагдахаар тохирлоо.</li> <li>• Үйлдвэрчний эвлэлийн нэрэмжит байгууллагын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээн 06 дугаар сарын 09-өөс 17-ны өдрүүдэд амжилттай болж зохион байгуулагдсан.</li> </ul>
2.9	Эрүүл мэндийн ажилтнуудыг мэргэжлийн болон боловсролын зэрэг хамгаалахад дэмжлэгт орчин бүрдүүлэх	Ажилтны мэргэжлийн ур чадвар, боловсрол дээшилнэ	Тухайн жилд боловсролын болон мэргэжлийн зэрэг ахиулсан ажилтны тоо, хувь				<p>Эрүүл мэндийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/354 дугаар тушаалаар тус эмнэлгийн мэргэжилтний зэрэг ахиулсан болон шинээр зэрэг хамгаалсан мэргэжилтний нэрс батлагдсан. Үүнд: Зөвлөх эмч 2, Зөвлөх сувилагч 1, Тэргүүлэх эмч 4, Тэргүүлэх эмнэлгийн тусгай мэргэжилтэн 1, Тэргүүлэх сувилагч 6, Ахлах эмч 7, Ахлах эм зүйч 1, Ахлах сувилагч 4, Ахлах хөдөлгөөн засалч 2 шинээр хамгаалж Тэргүүлэх эмч 2, тэргүүлэх эмнэлгийн тусгай мэргэжилтэн 1 тус тус мэргэшлийн зэргээ шинэчлэн тогтоолгосон бөгөөд Анагаах ухааны доктор 10, Зөвлөх эмч 11, Зөвлөх сувилагч 3, Тэргүүлэх</p>

								эмч 38, Тэргүүлэх сувилагч 41, Ахлах эмч 35, Ахлах сувилагч 23, бусад мэргэжилтэн 9 нийт 170 ажилтанд боловсролын болон зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10-20 хувиар тус тус нэмэгдэл олгосон.
2.1 0	Мөнгөн ба мөнгөн бус урамшууллын тогтолцоогоор ажлын гүйцэтгэлийг сайжруулах хөшүүрэг болгох	Ажилтны идэвхи дээшилнэ.	Мөнгөн ба мөнгөн бус урамшуулал авсан ажилтны бүртгэл судалгаа					<ul style="list-style-type: none"> <li>• 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн эмнэлгийн ажилтан, мэргэжилтний үндсэн цалинг 30%-иар нэмэгдүүлсэн.</li> <li>• Засгийн газрын 2023 оны 240,241 дүгээр тогтоолын дагуу Эмнэлгийн захирлын 2023 оны 07 дугаар сарын 19-ний А/75 дугаар тушаалаар эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг ханган ажилладаг эмнэлгийн туслах албан тушаалтны цалинг Засгийн газрын тогтоолоор батлагдсан цалингийн доод жишгээс 20%, эмнэлгийн төрийн үйлчилгээний эрүүл мэндийн ажилтны цалинг Засгийн газрын тогтоолоор батлагдсан цалингийн доод жишгээс 10%-иар тус тус нэмэгдүүлж шинэчлэн баталсан.</li> <li>• Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72,1 дэх заалт, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны А/59 дугаар тушаалын дагуу Шөнийн цагт ажилласны нэмэгдэл 163952 цагийн 163,952,000 төгрөг олгогдсон.</li> <li>• Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн дагуу илүү цагаар болон 7 хоногийн амралт, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажиллуулсны хөлс болох 3,323,570,825 төгрөгийг давхардсан тоогоор нийт 4994 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон.</li> <li>• Дуудагдан ажилласны хөлс болох 124,117,438.00 төгрөгийг давхардсан тоогоор нийт 959 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон.</li> <li>• Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 22.1 дэх заалтын дагуу эмнэлгийн хэмжээнд Анагаах ухааны доктор 10, Зөвлөх эмч 11, Зөвлөх сувилагч 3, Тэргүүлэх эмч 38, Тэргүүлэх сувилагч 41, Ахлах эмч 35, Ахлах сувилагч 23, бусад мэргэжилтэн 9 нийт 170 ажилтанд</li> </ul>

										<p>боловсролын болон зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10-20 хувиар тус тус тооцон 289,702,937.00 төгрөгийн нэмэгдэл олгосон</p> <ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 151 дүгээр тогтоолын дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл нийт 483 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 623,003,735.00 төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон.</li> <li>• Хөдөлмөрийн тухай хуулийн 108.1 дүгээр заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын дагуу хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийн нэмэгдэл 254,674,852.00 төгрөгийг 213 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон.</li> <li>• Алсын болон төрөлжсөн мэргэжлийн дуудлагаар явж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэний нэмэгдэл хөлсийг Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу нийт 8 эмнэлгийн мэргэжилтэн ажилтанд 368 586 төгрөг олгосон.</li> <li>• Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтын дагуу хоол, унааны нэмэгдэл 847,331,000.00 төгрөгийг 557 ажилтанд олгосон.</li> <li>• Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу ур чадварын нэмэгдлийг 28 ажилтанд 10%-иар тооцон нийт 37,082,986.00 төгрөг тооцон олгосон.</li> <li>• Хариуцлагын нэмэгдлийг 63 ажилтанд нийт 115,439,411.00 төгрөг тооцон олгосон.</li> <li>• Эмнэлэг сувилахуйн болон тусгай мэргэжилтний хомсдолд орж ажлын байрны ажлын ачаалал эрс нэмэгдсэнтэй холбоотой Ерөнхий захирлын 2022 оны А/99 дугаар тушаалаар 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сувилахуйн болон тусгай мэргэжилтнүүдэд үндсэн цалингийн 15 хувийн нэмэгдлийг олгон ажиллаж байна.</li> <li>• Хангамж, үйлчилгээний хэсгийн үйлчлэгчийн ажлын байранд ажиллах ажилтны хомсдол үүсч, батлагдсан орон тооноос</li> </ul>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

								<p>нэн дутуу ажиллан нэг үйлчлэгчид ноогдох ажлын ачаалал эрс нэмэгдсэн тул Ерөнхий захирлын 2022 оны Б/313 дугаар тушаалаар 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үндсэн цалингийн 20%-ийн нэмэгдэл олгон ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг бүрэн ханган ажилласан үйлчлэгч-13, жолооч-3, слесарь-3, шил угаагч-2, угаагч-2, ариутгагч-2, нярав-1, сувилагч-11, рентген техникч-1, лаборант-1 нийт 40 ажилтнуудад Эрүүл мэндийн салбарын ажилтны баярын өдрийг ториолдуулан 2,000,000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. (Эмнэлгийн захирлын 2023 оны А/71, А/83 дугаар тушаал)</li> <li>• Эрүүл мэндийн салбарын ажилтны баярын өдрөөр Эрүүл мэндийн яамны жуух бичгээр эмч-3, рентген техникч-3 сувилагч-2, цахим бүртгэл, лавлагааны ажилтан-3, инженер-1, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч-1 нийт 13 ажилтан, Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан тэмдгээр эмч-4, сувилагч-ариутгагч-1 нийт 5 ажилтан, хамтран ажиллагч байгууллагын гарын бэлгээр нийт 20 ажилтныг тус тус шагнаж урамшуулсан.</li> </ul>
2.1 1	Үр дүнгийн урамшууллыг Засгийн газрын холбогдох тогтоолын дагуу хэрэгжүүлэх	Ажилтны тогтвортой ажиллах боломж, сэтгэл ханамж нэмэгдэнэ	Үр дүнгийн урамшууллын дүн тайлан					<p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолоор тус тус батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам"-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор үнэлүүлдэг ба 2023 оны I улиралд 513 эмнэлгийн эрүүл мэндийн ажилтанд 254,541,184 төгрөг, II улиралд 504 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 273,498,056 төгрөг III улиралд 507 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 267,966,658 төгрөг, IV улиралд 537 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 332,356,135 төгрөг буюу нийт 1,128,362,033 төгрөг олгогдсон. (Эмнэлгийн ерөнхий захирлын 2023 оны А/41, А/70, А/105, А/141 тушаалууд)</p>
<b>Зорилт 3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах</b>								
3.1	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын	Чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж,	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь					"Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт 90%

	үндэсний хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийг	сэтгэл ханамж нэмэгдэнэ						2023 оны "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн тайлан"-г эрүүл мэндийн яамд хүргүүлсэн.
--	------------------------------------	-------------------------	--	--	--	--	--	---

Тайлан гаргасан:

Х.Болор (Захиргаа, хүний нөөцийн албаны менежер)

:

Тайлан хянасан:

Н.БАЯРМАА (Захиргаа, хүний нөөцийн албаны дарга)